



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/244

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 16 дахь заалтыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Аймгийн замын сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалт"-ын 2-ийн 2.1-д заасан арга хэмжээнээс Булган сумын Орон нутгийн хөгжлийн сангийн болон багийн иргэдийн хандивын хөрөнгөөр хэрэгжүүлж буй сумын төвөөс Баянсудал багийн хооронд тавьж байгаа сайжруулсан авто замын санхүүжилтийн дутууд 6.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Сайжруулсан автозамын ажилд зарцуулах 6.0 сая төгрөг /зургаан сая/-ийг аймгийн 2019 оны төсөвт батлагдсан замын сангийн хөрөнгөөс замын ажлын даалгавар, төсвийг үндэслэн санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/244 Ch  
02 01214